

ДОРНОД АЙМАГ
БҮСИЙН ОНОШИЛГОО ЭМЧИЛГЭЭНИЙ
ТӨВИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2022 оны 07 сарын 22 өдөр

Дугаар 8/51

Чойбалсан

Г Шагнаж урамшуулах тухай 7

Эрүүл мэндийн сайдын 2019 оны 565, 566 дугаар, 2022 оны 136 дугаар тушаалууд, Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн захирлын 2022 оны А/23 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Өвчний түүх, анхан шатны маягт хөтлөлтийг сайжруулах 45 хоногийн аянд байр эзэлсэн эмч, сувилагчдыг шагнаж урамшууллын хэмжээг хавсралтаар баталсугай.

2.Эмч, сувилагчдыг үндсэн цалингийн 15-40 хувиар 1 сар урамшуулах, урамшууллыг нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын зардлаас гарган олгохыг Эдийн засаг, санхүүгийн албаны дарга Сийлэгмаад зөвшөөрсүгэй.

3.Өвчний түүхийн бичилт болон анхан шатны маягт хөтлөлтийг хянаж хөтлөлтийг стандартын дагуу сайжруулж ажиллахыг Дотоод хяналтын ажилтан Д.Урантунгалагт үүрэг болгосугай.

